

**ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ,  
ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2023 оны 02 дүгээр сарын 28

Номгон

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгон төсөл, хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:**

Аймгийн хэмжээнд “Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь”, “Тогтвортой ноолуур төсөл”, “Утаагүй Баянхонгор төсөл”, “Малчдын эрүүл мэндийг хамгаалах, малчдыг аливаа эрсдэлт өвчин эмгэгээс сэргийлэх”, “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл, “Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” төсөл, “Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах” төсөл, “Best хөтөлбөр”, “Тогтвортой Амьжиргаа-3” зэрэг төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Төсөл хөтөлбөр	Хэрэгжиж буй сумдын тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4
1	Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь	4	100%
2	Тогтвортой ноолуур	7	100%
3	Утаагүй Баянхонгор	1	95%
4	Малчдын эрүүл мэндийг хамгаалах, малчдыг аливаа эрсдэлт өвчин эмгэгээс сэргийлэх	20	90%
5	Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ	20	98%
6	Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө	20	100%
7	Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах	20	96,8%
8	Best хөтөлбөр	1	100%
9	Тогтвортой Амьжиргаа-3	20	100%

**“Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төсөл**

Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь төсөл хөтөлбөрийг Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хэрэгжүүлсэн.

Бэлчээр, ойн доройтлыг бууруулах замаар Соён, Хангайн уулс, өмнийн Говийн эко системийн үйлчилгээг сайжруулах, тогтвортой амьжиргааг дэмжиж биологийн олон янз байдлыг хамгаалах зорилготой төсөл юм.

Төслийн зорилт:

1.Бэлчээр, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн, биологийн олон янз байдлыг хамгаалах замаар экосистемийн үйлчилгээг өргөжүүлэхэд шаардлагатай тогтолцоог бий болгон чадавхыг бэхжүүлэх;

2.Бэлчээр, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн биологийн олон янз байдлыг хамгаалах замаар газрын доройтол/цөлжилтийг бууруулж, экосистемийн үйлчилгээг өргөжүүлэх;


3.Орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих замаар биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийн үйлчилгээг сайжруулах;

4.Мэдээлэл, мэдлэг солилцох, түгээх болон хяналт шинжилгээ, жендерийн асуудлыг бүх түвшинд авч үзэх тогтолцоог хангах;

Төсөл говийн бус буюу Баянхонгор аймгийн Баацагаан, Баянцагаан, Шинэжинст, Баян-өндөр сумдад хэрэгжсэн.

Нийт санхүүжилт 426,275,219 төгрөг.

Төсөл хэрэгжиж буй 4 аймгуудын нутаг дэвсгэрт нийт 1 096 604.6 га газар талбай бүхий 11 газрыг тусгай хамгаалалтад авсан ба Бөөнцагаан нуурыг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг өргөн мэдүүлэх, тусгай хамгаалалтад авах үндэслэл, ач холбогдол, хил хязгаарын талаар Баянхонгор аймгийн ЗДТГ, ИТХ, БОАЖГ, ГХБХБГ, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, Баацагаан сумын ЗДТГ, орон нутгийн иргэдтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж санал солилцсоны үндсэн дээр тус нуурын цутгал голуудын экологийн төлөв байдалд үнэлгээ хийж, бүхэл сав газрын түвшинд хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай гэж үзэн “Байдраг голын сав газрын экологийн чадавхыг ландшафтын түвшинд үнэлэх, цаашид зохистой ашиглах, хамгаалах үндэслэл” боловсруулах суурь судалгааг ШУА, эрдэмтэн, судлаачид гүйцэтгэж 363063 га талбайг тусгай хамгаалалтад авах боломжтой гэсэн зөвлөмж боловсруулсан.



Зураг 1. Байдраг голын сав газарт тусгай хамгаалалтад авахаар санал болгож буй газар нутаг Малын тоо толгойн албан татварын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан татвараас төвлөрсөн орлогыг зарцуулах чиглэлд “Малын тоо толгойн албан татварыг зарцуулах үлгэрчилсэн журам”-ын төслийг боловсруулж, зөвлөмж гарган Сангийн яам болон ХХААХҮЯ-нд баталгаажуулахаар хүргүүлсэн. Тус журмыг хэрэгжүүлэхээр Баянхонгор аймгийн Баянцагаан сум дэмжиж ИТХ-ийн тогтоол гаргасан.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад “тусгай зориулалтаар” сан байгуулах эрхийг орон нутгийн ИТХ-д олгосны дагуу “Баянцагаан” Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газрын менежментийг санхүүжүүлэх зорилгоор “Баянцагаан” байгаль хамгаалах санг байгуулахаар холбогдох талуудтай (сумын ИТХ, ЗДТГ, “Лүүк Монголия” ХХК) зөвшилцсөний үр дүнд сумын ИТХ-ын 10 дугаар тогтоолоор Баянцагаан сан байгуулах, сангийн дүрэм, захиргааны хэм хэмжээний актад нөлөөллийн шинжилгээг хийж улсын бүртгэлд бүртгүүлэх, төрийн санд данс нээлгэхээр ХЗДХЯ болон Сангийн яаманд албан хүсэлт илгээсэн.

Төслийн зорилтот сумдын бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлт, нөхөн сэргэх чадавхыг үнэлэх ажлыг жил бүр тогтсон хугацаанд явуулдаг. Энэ хүрээнд 13 сумын бэлчээрт шинээр тогтоосон УЦУОШТ-ийн ажиглалтын 56 цэг, газрын хянан баталгааны фото мониторингийн 76 цэгийг оролцуулан нийт 240 цэгт улсын хэмжээнд баримтлах шугаман цэгийн арга зүйг ашиглан хэмжилт, бичиглэл хийж, ургацын дээж материал цуглуулан бэлчээрийн ХШҮ-г тухайн сумдын газрын даамал, ХАА-н тасгийн мэргэжилтэн, УЦУОШТ-ийн инженер, техникийн

ажилтнуудтай хамтран гүйцэтгэж үнэлгээний үр дүнг “Ланд менежер” мэдээллийн санд оруулан ажилласан

Баянхонгор аймгийн Баацагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумууд бэлчээрийн даац хэтрэлтгүй, нөөц бэлчээртэй болж сайжирсан байна.

Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутагт өвс тэжээлийн нөөц бий болгох, малчны бүлгүүдийн малын тэжээлийн хангамжийг тодорхой түвшинд шийдвэрлэх зорилгоор Баянцагаан сумын хуучин Цагдуултын усралтын системийн 50 га нийт 140 га газрыг хашаажуулж, хашсан талбайн хөрсний судалгааг хийж, таримлын төрөл зүйл сонголт болон усалгааны норм стандартын зөвлөмж боловсруулж өглөө.

Баянхонгор аймгийн Баянцагаан сум 20 га талбайд нэг наст овьёос, 5 га талбайд царгас, согоовор тариалж 8 тн ургац хураан авч сумын өвс тэжээлийн нөөц болон малчдын 2 бүлэгт дэмжлэг үзүүлсэн байна.

МБАНХ ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй малын чанар сайжруулах, генетик нөөцийг хамгаалах ажлын хүрээнд 2022 онд Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Баацагаан, Шинэжинст сумдын “Малын үржлийн ажлын ойрын болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө 2021-2030”-г боловсруулж, сумдын ИТХ-аар батлуулснаар мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын баримт бичигтэй болсон.

МҮТАҮН-ийн өмч, эзэмшилд хүлээлгэн өгсөн сайжруулагч үүлдэр, үржлийн хэсгийн хээлтүүлэгч, хээлтэгч малын ашиглалтаар Баянцагаан сум хуцаа 100 хувь, түрээслүүлж түрээсийн орлогыг бүрдүүлэн ажилласан байна.

Баянхонгор аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж аймгийн БОАЖГ-т хэлэлцүүлэн хүлээлгэж өгсөн. Мөн тус аймгийн говийн бүст ойжуулалтын талбай сонгох, сонгосон газруудад тарих модны төрөл зүйл сонгох чиглэлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх хээрийн судалгааг явуулсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Мод тарих 1000 сургагч багш бэлтгэх” ажилд дэмжлэг үзүүлж 15 минутын 9 агуулга бүхий видео хичээл, зааварчилгааг бэлтгэсэн. Мөн мод тарих, үржүүлэх, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, ойн зурвас бий болгох, хот цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж байгуулах онол, практикийн сургалтыг Баянхонгор аймгийн 20 сумын суралцагчдад зохион байгуулж 60 сургагч багш бэлтгэгдсэн.

Орон нутгийн Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн менежментийн үр нөлөөг сайжруулах, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэх, шинээр тусгай хамгаалалтад авсан газруудын менежментийг сайжруулахад

дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд цөлжүү хээрийн эмзэг экосистемийг төлөөлж буй Баянхонгор аймгийн Баянцагаан сумын “Баянцагааны нуруу”-ны Орон нутгийн тусгай хамгаалалттай газарт БОАЖЯ-наас батлан гаргасан зааварчилгааны дагуу тэмдэгжүүлэх ажлыг чанар, стандартын түвшинд гүйцэтгэн сумын ЗДТГ-т хүлээлгэн өглөө.



Зураг 2. Баянцагаан ОНТХГ-ын тэмдэг, тэмдэглэгээ

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/19 тоот захирамжаар “Баянцагаан Орон нутгийн тусгай хамгаалалтын хэсгийг 1 ахлагч, 3 идэвхтэн байгаль хамгаалагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан. Байгаль хамгаалагч нар төлөвлөгөөт эргүүлийг тогтмол хугацаанд ЗДТГ, Цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэж хууль бус ан агнууртай холбоотой 15 хавх, 10 урхи хураан устгалд оруулсан. Мөн нутгийн малчдад Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын журам, байгаль орчны тухай хууль, байгаль орчноо хайрлан хамгаалах сэдвээр мэдээлэл, сургалт явуулж, зэрлэг ан амьтны байршил нутаг болох Урд зуслан, Хойд зуслан, Хальсны ам, Бага өл, Хөндлөн зэрэг газруудыг бэлчээрээс чөлөөлсөн нь үр дүнтэй ажил боллоо. Ийнхүү менежментийн мастер төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг явуулахад төсөл болон агнуурын менежментийг хариуцагч “Лүүк Монголиа” ХХК-тай хамтран 30 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэж, байгаль хамгаалагчдын цалин урамшуулал болон Ан амьтадын голчлон нутагладаг бүс нутгуудад биотехникийн ажлын хүрээнд марз, мараа бүхий газрууд бий болгох, идэвхтэн байгаль хамгаалагч нарт шаардлагатай дүрэмт хувцас, GPS, аранзаар хангах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Говийн бүсийн байгаль хамгаалагчдын туршлага солилцох уулзалтыг Говийн Их Дархан Цаазат Газрын А хэсгийн орчны бүсийн 5 сумын 9 хамгаалалтын захиргаа, 6 байгаль хамгаалах нөхөрлөл, БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч, хамгаалалтын захиргаадын мэргэжилтэн нийт 130 хүн оролцуулан зохион байгууллаа.



**Зураг 3.** Говийн бүсийн УТХГ-ын хамгаалалтын захиргаадын мэргэжилтэн байгаль хамгаалагч, ГИДЦГ-ын А хэсгийн орчны бүсийн 5 сумын БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн уулзалт, зөвлөгөөн

Төслийн зорилтот 13 суманд байгуулагдсан 225 малчны бүлгүүдийн малын тэжээлийн хангамж, ашиг шимийг нэмэгдүүлэх замаар бэлчээрийн даац ачааллыг бууруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд Баянхонгор аймгийн Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумын малчдад орон нутагт малын тэжээлийн нөөц, чанар, хангамжийг сайжруулах зорилгоор орон нутагт олдоц, ихтэй тэжээлийн ургамлууд, түүхий эдийн найрлага, шимт чанар, түүгээр дарш бэлтгэх арга технологи, ач холбогдол, даршаар төрөл бүрийн малыг тэжээх норм, хэмжээ, арга, ажиллагааг зааж сургах практик сургалт зохион байгуулсан.



**Зураг 3.** Ногоон тэжээлийн ургамлаар дарш бэлтгэх сургалтын явц

Малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бэлчээрийн ачааллыг бууруулах зорилгоор хурга махлуулах туршилтын ажлыг Баянхонгор аймгийн Баянцагаан сум, Архангай аймгийн Өлзийт сумын малчдын бүлэгт зохион байгуулав.

Орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих замаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийн үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд говийн бүс нутагт жимс жимсгэний тариалалт, ялангуяа импорт орлох жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хармаг тариалах, таримал болон зэрлэг хармаг жимсийг боловсруулж зах зээлд нийлүүлэх, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг 2022 онд зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд 2 удаагийн практик сургалтад Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Завхан аймгийн 13 сумын 27 малчин оролцож жимс жимсгэнийн аж ахуй эрхлэхэд үр тарихаас эхлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалтыг онол ба дадлага ажлуудтай хослуулан явууллаа.

Төслийн зорилтот нутагт амьдарч буй өрхийн амьжиргааны дунд шатны судалгааг 2022 онд зохион байгууллаа. Судалгааны дүнгээс харахад төслийн зорилтот нутаг дэвсгэрийн хүрээнд өрхийн жилийн нийт бодит орлого 2022 оны байдлаар 10,2 сая төгрөг, орлогын гол эх үүсвэр нь МАА-н орлого байна. Төсөлд хамрагдсан өрхийн нийт орлого төсөлд хамрагдаагүй өрхөөс 13 хувиар илүү, суурь судалгааны дундаж орлогоос 33 хувиар илүү байна. Эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн дундаж орлого эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн орлогоос 50 хувиар илүү бөгөөд суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад эрэгтэй өрхийн тэргүүний орлого 24 хувиар, эмэгтэй өрхийн тэргүүний орлого 9 хувиар нэмэгджээ. Дараах хүснэгтэд өрхийн орлогыг суурь болон дунд шатны судалгааны өрхийн орлогын өөрчлөлтийг харьцуулан харуулж байна.

**Хүснэгт 1. Өрхийн амьжиргааны судалгааны үр дүн**

Үзүүлэлт	Суурь судалгааны орлогын түвшин, 2019 он	ДШС-ны бодит орлогын түвшин, 2022 он	Өөрчлөлт
Эрэгтэй өрхийн тэргүүн	8,690,470	10,749,415	24%
Эмэгтэй өрхийн тэргүүн	6,559,729	7,164,633	9%
Орлогын ялгаа, өрхийн тэргүүний хүйсээр	32%	50%	18%
Нийт өрхийн дундаж		10,222,180	21%
Төсөлд хамрагдсан өрхийн дундаж орлого	8,465,023	11,221,894	33%**
Төсөлд хамрагдаагүй өрхийн дундаж орлого		9,935,607	17%**

\*\*Суурь судалгаанд төсөлд хамрагдсан өрхийн орлогын түвшин тодорхойлогдох боломжгүй тул нийт өрхийн дундаж орлоготой харьцуулан гаргасан.

Судалгааны дүнгээс харахад төслөөс малчдын бүлэг, нөхөрлөлийн гишүүдийн ажлын байр болон орлогыг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлууд үр дүнгээ өгч байгааг харуулж байна. 2022 оны хувьд зорилтот бүс нутгийн малчдын амьжиргааг дэмжих зорилгоор нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сүү, мах, ноос, жимс жимсгэний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.

**Сүүний нэмүү өртгийн сүлжээ:** Завхан аймгийн Их-Уул сум, Баянхонгор аймгийн Баян-өндөр сум, Архангай аймгийн Батцэнгэл сумдын ЗДТГ, малчдын бүлэг, төслийн түншлэлийн хүрээнд инновацын бүтээгдэхүүн болох пробиотик сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж, тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт, сүүн бүтээгдэхүүний технологийн чиглэлээр сүү боловсруулах цехийн ажилтнууд болон малчдын мэдлэг, ур чадварыг сайжрууллаа. Энэхүү түншлэлийн үр дүнд төслөөс 126 сая төгрөг, орон нутгаас

150 сая төгрөгийн хамтын санхүүжилтээр 2021 онд Завхан аймгийн Их-Уул суманд, 2022 онд Баянхонгор аймгийн Баян-өндөр сум, Архангай аймгийн Батцэнгэл суманд өдөрт 1 тонн сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр тус тус байгуулагдлаа. Үйлдвэр байгуулснаар нийт 12 шинэ ажлын байр бий болж, малчдын бүлгээс жилдээ 300 гаруй сая төгрөгийн сүү худалдан авч, малчдын өрхийн орлогыг нэмж, орон нутагт үйлдвэрийн аргаар боловсруулсан 7-8 төрлийн пробиотик бүтээгдэхүүн бий болж, тэдгээрийг сумын эмнэлэг, сургуулийн үдийн цай хөтөлбөр, иргэдийн хэрэгцээнд нийлүүлэх боломжтой болж байна.



Зураг 5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

**Ноосны нэмүү өртгийн сүлжээ:** Малчдын амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ноос бэлтгэн нийлүүлэлт, чанарыг сайжруулах дэвшилтэт технологи ашиглан хонины ноос хяргах, ангилан ялгах анхан шатны сургалтад Баянхонгор аймгийн Баянцагаан, Говь-Алтай аймгийн Цогт, Завхан аймгийн Тосонцэнгэл сумдын 13 малчин амжилттай суралцаж хонийг хайчаар хяргадаг уламжлалт аргачлалтай харьцуулахад өдрийн бүтээмжийг 10 дахин нэмэх шинэ технологи ашиглан ноосоо хяргаж сурснаас гадна ноосыг ангилан ялгах аргачлалд суралцсанаар ноосны гарц, хэмжээ, үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэх боломжтой боллоо. Эдгээр оролцогчдоос ноос хяргах олон улсын стандарт хангасан 4 оролцогч 2 дахь түвшний сертификатыг авсан бөгөөд 2 одтой сертификат авсан 1 оролцогч Шинэ Зеланд улсад сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдах, ноос хяргагчаар богино хугацаанд ажиллах шалгуур хангалаа. Сургалтад хамрагдсан малчид нь төслийн бэлчээрийн менежментийг сайжруулах зорилтын хүрээнд байгуулсан малчдын бүлэг болон хоршоодын гишүүд бөгөөд цаашид хонь хяргах баг бүрдүүлж ноос хяргах машин, дэвшилтэт технологи ашиглан сумын болон бүлгийн малчин өрхүүдийн хонины ноосыг хяргаж, ангилан үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжтой болсон байна.

**Жимс, жимсгэнийн нэмүү өртгийн сүлжээ:** Төсөл хэрэгжиж буй 13 суманд ХАА-н болон ойн дагалт баялаг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж нэмүү өртгийн



сүлжээг хөгжүүлэх замаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, Эко системийн үйлдвэрлэлийг сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

Бичил төсөл хэрэгжүүлж буй ТББ-ын нэг болох Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны Мөнгөлөг тооройн төгөл ТББ-ын “Эко клубийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалт зохион байгуулах” төсөл нь 2022 онд Говь-Алтай аймгийн 5, Баянхонгор аймгийн 2 эко клубийн 218 сурагчид сургалт зохион байгуулж, хог хаягдал ангилан ялгах, дадал хэвшлийг бий болгох зорилгоор клубийн сурагчидтай хамтран хог хаягдал ангилан ялгах буланг тохижуулан 7 суманд хүлээлгэн өглөө. Мөн клубийн сурагчид сургалтаар олж авсан мэдлэгээ бататгах зорилгоор сумандаа хог хаягдлыг бууруулах, албан байгууллагуудыг цэцэгжүүлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг аянуудыг зохион байгуулж байна.



**Зураг 6.** “Эко клубийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалт

Төслийн зүгээс нутгийн иргэд, сургууль, эко клубуудийг Биологийн олон янз байдлын хамгаалал, мониторинг хийх, нутгийн иргэд, ЕБС-ын сурагчдад нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсээр ирсэн. Энэ ажлын хүрээнд 2022 онд Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Говийн Их Дархан Цаазат Газрын А хэсгийн Орчны бүсийн сумдын ЕБС, сургуулийн эко-клубийн удирдагч багш нар, гишүүн сурагчдыг чадавхжуулах, олон нийтийн мэдээллийн ажилд дадлагажуулах зорилгоор “Өсвөрийн сурвалжлагч”, “Эко-сургууль”, “Нүүдэлчин авдар” зэрэг сургалтыг орчны бүсийн нийт 7, ЕБС-ийн 8 эко-клубийн багш, сурагчдад зохион байгууллаа. Говийн Их Дархан Цаазат Газрын А хэсгийн Орчны бүсийн сумд болох Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумдын сургуульд тус бүрд нөлөөллийн ажлын тоног төхөөрөмжийн багцыг гардуулав. Тус багцад зөөврийн компьютер, проектор, дэлгэц, дуу өсгөгч багтсан бөгөөд сургуулийн эко клубээс зохион байгуулдаг олон нийтийг хамарсан нөлөөллийн ажилд хэрэглэж байна.



**Зураг 7.** ГИДЦГ-ын А хэсгийн Орчны бүсийн сумдын ЕБС, сургуулийн эко-клубын удирдагч багш нарт гардуулсан тоног төхөөрөмж

Үндэсний болон орон нутгийн удирдлага, нийгмийн хүрээний болон ашиг хүртэгчдийн түвшинд Мэдлэг, хандлага, дадлын судалгаа (КАР), Ногоон хөгжлийг хэрэгжүүлэх замаар экосистемийн үйлчилгээг сайжруулах чадавхын үнэлгээг төслөөс зохион байгууллаа. Мэдлэг, хандлага, дадлын судалгааны үр дүнгээс харахад төслийн хүрээнд зохион байгуулсан мэдлэг олгох сургалтын үзүүлэлтүүд 2019 онтой харьцуулахад 227% буюу 2.7 дахин өссөн байна. Үүнд, мэдлэгийн түвшин 6.6%-д хүрч 3,91%-иар, туршлагын түвшин 24.63%-д хүрч 3,91%-иар өссөн. Харин бэлчээр, ойн нөөц, ховор амьтан, ургамлыг хамгаалах иргэдийн хандлагад 2019 онтой харьцуулахад тооны хувьд томоохон өөрчлөлт гараагүй, хандлагын түвшин 73 хувьтай буюу 2019 онтой харьцуулахад 1 хувиар буурсан ч иргэд өөрсдийн зүгээс арга хэмжээ хэрэгжүүлэхтэй санал нэгтэй болж, байгалийн хүчин зүйл, бусад гаднын хүчин зүйл, мөн “миний мэдэх асуудал биш, би юу ч хийж мэдэхгүй” гэсэн сөрөг хандлагууд бүгд эергээр солигдсон сайн үр дүн гарсан байна. Суурь түвшинтэй харьцуулахад байгаль орчин болон Биологийн олон янз байдлын хамгааллын дадал зуршил 12,8%-иар өссөн байна.

Зэрлэг амьтан ургамал хамгаалах ОУ-ын өдөр, Байгалийн олон янз байдлыг хамгаалах өдөр, Байгаль орчны өдөр, Цөлжилттэй тэмцэх өдөр зэрэг байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийх, шилдэг туршлагыг баримтжуулан түгээх ажлыг БОАЖЯ болон орон нутгийн холбогдох байгууллагаас зохион байгуулахад нь төслөөс дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байна. Тухайлбал, Цөлжилттэй тэмцэх өдөр, “Гангийн үр дагаврыг хамтдаа давъя” уриан дор 6 дугаар сарын 17-нд тэмдэглэсэн өдрийн хүрээнд газрын доройтлыг бууруулах чиглэлээр төслийн хэрэгжүүлж буй сайн туршлага Баянхонгор аймгийн Баянцагаан сумын бэлчээр хамгаалах сангийн санаачилга, Цагдуултайн услалтын системд түшиглэсэн малын тэжээл тариалах ажил, малын баасаар бордоо хийж буй бичил төслийн санаачилгын талаар 3 видео контент бүтээж, төслийн цахим платформуудаар түгээв. Төслийн хэрэгжилт 100 хувь.

## Тогтвортой ноолуур (SPI-CD) Тогтвортой Ноолуур Үйлдвэрлэлийн Цогц Систем бий болгох нь

Санхүүжилт: Төслийн урьдчилсан төсөв: 2.860.442 евро

1. Санхүүжүүлэгч: FFEM буюу Дэлхийн байгаль орчны төлөө Францын Сан:
2. Европын Холбоо; Хоршоодын Холбоо; WCS=ЗАХН; Орон нутгийн удирдлагууд (Баянхонгор аймгийн засаг даргын Тамгын газар, ХХААГ, сумдын ЗДТГ, ИТХ)-(ХАА тасаг, мал эмнэлгийн тасаг), AVSF: Урьдчилсан нийт дүнгээр 2.010.442 еврогийн санхүүжилтийг хамтран гаргахаар төлөвлөж байна.

Төсөв /Нийт шаардагдах зардал/ 850 000 евро Төсөв /он/ 2022 он: 228 475 евро  
Гүйцэтгэл 173 509 евро, Хувь 76%

**Зорилго:** Цөлжилтийг бууруулахад хувь нэмрээ оруулж, Монгол улсын хөдөө орон нутгийн эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтолцооны уялдаа холбоог бэхжүүлэх юм.

**Зорилт:** Ноолуурын бэлтгэл, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг нэмэгдүүлж, энэ салбарыг Монгол улсад “тогтвортой хөдөө аж ахуйн хөгжил”-ийн гол хүчин зүйлээр хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан цаашлаад хууль эрх зүйн бодлогын баримт бичигт тусгах явдал юм.

**Хөтөлбөрийн агуулга:**

Европын Холбоо (EU) болон Дэлхийн Байгаль Орчны Төлөө Францын Сан (FFEM)-гийн санхүүжилтээр AVSF (Хил хязгааргүй Малын Эмч нар ба Агрономчид ОУТББ)-с хэрэгжүүлсэн “Тогтвортой Ноолуур” төслийн үзэл санаа, агуулгад үндэслэн “Тогтвортой Ноолуур Үйлдвэрлэлийн Цогц Системийг бий болгох нь” (SPI-CD) нэртэй төслийг 2020-2023 онд Монгол Улсын Баянхонгор аймгийн 7 суманд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Өмнөх төслүүдээс урган гарсан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, төсөлд хамрагдагчдыг илүү бие даасан болгох, төслийн хамрах хүрээг өргөтгөх, төслийн үр дүнг хууль эрх зүйн хүрээнд албажуулах чиглэлд анхааран ажиллана.

Төсөл нь эдийн засгийн үнэ цэнэ бий болгох зарчмыг баримтална. Өөрөөр хэлбэл малчдыг идэвхжүүлж тогтвортой ноолуур нийлүүлэлтийн сүлжээний эдийн засгийн үр шимийг ойлгуулан, малчид зохион байгуулалтад орсноор байгаль, эдийн засгийн хүрээнд үүсэж болохуйц эрсдэлийг хамт даван гарахад нь туслах, түүхий эд бэлтгэлийн чанар, мал аж ахуйн арга барил, бэлчээрийн менежментийг сайжруулах юм. Үүнээс гадна өмнөх төслийн эхний шатанд хэрэгжүүлсэн загварт үндэслэн малчдын байгаль орчиндоо ээлтэй хандах хандлагыг сайжруулах замаар

сүүлийн хэдэн арван жилийн турш асар их доройтолд орчхоод байгаа бэлчээр нутаг дахь сөрөг нөлөөг бууруулахад оршиж байгаа юм.

Хамрах бүс нутаг: Монгол Улсын Баянхонгор аймгийн Богд, Жинст, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Бөмбөгөр зэрэг 7 сум.

Төсөлт хөтөлбөрийн зорилт :

Тогтвортой ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг амжилттай үргэлжлүүлэхэд маш олон төрлийн бүрдэл хэсгүүдийг “нэгтгэх” асуудал чухал байгаа учраас дээрх сорилтуудад гарц шийдэл олохын тулд 4 нэмэлт БҮРДЭЛ ХЭСГИЙН хүрээнд төсөл хэрэгжинэ. Үүнд:

1.Баянхонгор аймгийн Бэлчээр Ашиглагчдын Хэсгийн (БАХ) загвар болон Тогтвортой ноолуур Хоршооллын системд суурилсан “Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн цогц систем бий болгох” төслийг бэхжүүлэх;

2.“Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн цогц систем бий болгох” төслийн загварыг тогтвортойгоор түгээн дэлгэрүүлэх нөхцөлүүдийг (эдийн засгийн, бүтцийн, хууль эрх зүйн) хэрэгжүүлэх, сүлжээг хөгжүүлэх;

3.Зах зээлд нэвтэрч санхүүгийн боломжуудыг бий болгохтой холбоотой “Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн цогц систем бий болгох” төслийн загварын урьтал нөхцөлүүдийг тодорхойлж түгээн дэлгэрүүлэх, таниулах арга замыг хэрэгжүүлэх;

4.Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөг дүгнэх хяналт үнэлгээний ажлыг зохион байгуулж нөлөөлөл сурталчилгааны үйл ажиллагааг хянах, санхүүжилтийг тодорхойлох;

Бэлчээр доройтолтын асуудалд гарц шийдэл олж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөндөх мөн нийгэм-эдийн засгийн уян хатан шилжилтийг дэмжих зорилгоор Хил Хязгааргүй Малын эмч нар ба Агрономчид ТББ-аас Баянхонгор аймагт Тогтвортой Ноолуурын үйлдвэрлэлийн цогц үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлж чадсан. Уг төсөл нь Европын Холбоо болон ДБОТФС-гийн дэмжлэгтэйгээр 2013-2018 онд хэрэгжихдээ малчдад мал аж ахуйн практикаа илүү үр өгөөжтэй, байгаль орчинд ээлтэй болгох чиглэлд уриалан нөлөөлсөн. Иймээс ч 2020-2023 оны дуустал дахин шинээр 2 сумыг хамруулан 7 суманд үргэлжлүүлэн хэрэгжиж байна.

AVSF нь Архангай аймгийн Сарлагийн Нэмүү Өртгийн Сүлжээг бүтэцлэн хөгжүүлэх, (2010-2018 онд) мөн Баянхонгор аймгийн Тогтвортой Ноолуур Хөтөлбөрийн (2013 онд эхэлсэн) чиглэлд ажилласан 9 жилийн туршлагадаа

үндэслэн Монгол улсын Ноолуурын салбарт анхдагч гэж хэлж болохуйц “сайн туршлага”-ыг бүрэлдүүлж чадсан.

2022 оны төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, биелэлт:

1. Бэлчээр Ашиглагчдын Хэсэг (БАХ) болон Баянхонгор аймаг дахь Хоршооллын системийн загварт суурилсан SPI-CD төслийг бэхжүүлэх хүрээнд:

Ноолуур үйлдвэрлэлийн чанарыг тасралтгүй сайжруулан олж авсан арга туршлагаа бэхжүүлж, түгээн дэлгэрүүлэхийн тулд малын удам сайжруулах, өвс тэжээл, эрүүл мэнд гэсэн 3 гол хөтөлбөрүүдийг төсөл хэрэгжиж байгаа Баянхонгор аймгийн 7 сумын МАА тасаг, мөн өмнөх төслийн хүрээнд хамтран ажиллаж байсан Богд, Жинст, Шинэжинст, Баацагаан, Бөмбөгөр сумдын малчдын хоршоод, Бэлчээр ашиглагчдын Хэсгүүд (БАХ) болон 2021 оноос Төслийн дэмжлэгтэйгээр шинээр үүсгэн байгуулагдсан Баян-Өндөр, Баянцагаан сумдын малчдын хоршоод, малчны бүлгүүдтэй хамтран хэрэгжүүлж байна.

*Малын удмыг сайжруулах:*

Энэ үйл ажиллагааны хүрээнд төсөл хэрэгжиж байгаа зорилтот сумдад (Богд, Жинст, Шинэжинст, Баацагаан, Бөмбөгөр, Баянцагаан, Баян-Өндөр) чанартай (микрон, өнгө) ноолуурын гарц бүхий өндөр ашиг шимт ямааны ЦӨМ сүргийн ээмэгжүүлэлт, бүртгэлийн ажлыг 2022 оны 4 сард гүйцэтгэсэн.

2022 онд 7 хоршооны малын удмын санг сайжруулах, ноолуурын чанарыг хадгалах зорилгоор Шинэжинст сумын Залаажинст, Идрэн үүлдрийн 20 ухныг 7 хоршооны цөм сүрэгт, Залаажинст, Идрэн үүлдрийн 150 эм ямаа (ишигтэй) нь Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагааны хоршоонд, Бөмбөгөрийн улаан омгийн 50 эм ямааг (ишигтэй) Бөмбөгөр сумдын хоршоонд төслийн зүгээс олголоо. Сумдын мал зүйч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, МАА-н мэргэжилтнүүд хоршооны цөм сүргийн бүрдэлт, бүртгэл, үржлийн ажилд хяналт тавин ажиллахаар болсон.

*1.Төслийн хоршоодод 2022 онд байгаа цөм сүргийн өрх, ямааны судалгаа*

№	Сум, хоршооны нэр	малчин	Ямааны тоо	Хээлтэгч		Хээлтүүлэгч		Төл	Эр, бусад	2022онд төслөөс хандивласан			Нийт цөм сүргийн тоо
				Нас гүйцсэн	Өсвөр	Нас гүйцсэн	Өсвөр			Ухна	Эм ямаа	Төл	
1	Богд, "Орогнуурын Хишиг"	-	-	-	-	-	-	-	-	2			2
2	Жинст, "Түйн Хишиг"	2	35	25	0		10	0	2				47
			10		10								
3	Баацагаан, Цанхир хайрхан	1	46	18	8	0	0	15	5	2			48

4	Шинэжинст, Цармын цагаан сувд	1	39		24			12	3	4	50	50	143
5	Бөмбөгөр, Өгөөж баян- Өлзийт гол	1	65		37			28		2	50	50	167
6	Баян-Өндөр Идрэнгийн цагаан сувд		0							2	50	50	102
7	Баянцагаан Баянгичгэнэ		0							2	50	50	102
<b>Бүгд дүн</b>		<b>5</b>	<b>162</b>	<b>114</b>	<b>19</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>19</b>	<b>16</b>	<b>200</b>	<b>200</b>	<b>611</b>	

*Малын өвс тэжээл:*

2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор 7 сумын хоршоод өөрсдийн өвс тэжээлийн нөөц сангаасаа нийт 28 тн өвс, 51,2 тн хивэг, 9,1 тн овьёос, 5,6 тн хорголжин тэжээлийг 57,660,000 төгрөгөөр бэлтгэсэн байна.

*Малын эрүүл мэнд:*

Тайлант хугацаанд 7 сумын хоршоод сумын малын эмчтэй гэрээ байгуулан ажилласан ба нийт 146,335 толгой малыг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулсан байна.

Төсөл хэрэгжсэн хугацаанд (2022) Баянхонгор аймгийн Богд, Жинст, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Бөмбөгөр сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж бэлчээр нутгийг зөв зохистой ашиглах сайн туршлагыг дагаж мөрдөх ба зөв менежмент, хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор сум бүрд “Төслийн Зөвлөлдөх Хороо”-г сумын засаг засаг даргын захирамжаар байгууллаа. Энэ нь Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, орон нутгийн төрийн байгууллагууд, төслөөс ашиг хүртэгч малчид, тэдний байгууллага болон төслийн байгууллагын хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэсэн чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болсон.

Нүүдлийн мал аж ахуйд чухал мэдээлэл болох “Бэлчээрийн чанар, төлөв байдлын үнэлгээ хийх” ажлыг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор төсөл хэрэгждэг сумдад хийж байна. Үнэлгээнээс гарсан мэдээллийг цаг тухайд нь сумдын малчдад тэдний БАХ (Бэлчээр ашиглагчдын хэсэг)–аар дамжуулан хүргэх нь малчид отор нүүдэл хийх, малаа бэлчээрийн даацдаа тохируулан зах зээлд борлуулах зэрэг ажлуудыг цаг алдалгүй хийн тодорхой хэмжээнд гарз хохирол багатай гарсан үр дүнтэй байна. Энэ ажлыг төслийн зүгээс санхүүгийн болон арга зүйн хувьд дэмжиж, сумдын газрын даамлуудаар хийж гүйцэтгүүлсэн. Тухайлбал 2022 онд төслийн 7 сумын Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг хийх ажлыг төслийн багаас нэгдсэн удирдлагаар ханган газрын даамлуудад шатахууны

дэмжлэг өгч ажиллалаа. Үүнээс гадна эдгээр газрын даамлууд судалгааны мэдээллээ боловсруулах, хэвлэх, сумдын нийт малчдад мэдээллийг хүргэдэг байх боломжийг бүрдүүлж 15 сая төгрөгийн тоног төхөөрөмж, гарын авлага, бусад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь газрын даамлууд жил бүр бэлчээрийн үнэлгээ хийх ажлын чанар, үр өгөөж нь нэмэгдсэн байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 7 сумдад нийт 149 цэгээс 1937 зураг авалт хийж, 447 орчим дээж цуглуулж мэдээллийг боловсруулалт хийсэн бөгөөд 2022 оны 12 сард төсөл хэрэгждэг сумдын малчдын хоршоодын бүх гишүүдийн хурлууд, зарим БАХ-дийн хурлаар 2022 оны бэлчээрийн төлөв байдлын үнэлгээний мэдээллийг хүргүүлсэн нь малчдад малаа онд мэнд оруулах, бэлчээрээ зөв хуваарилах, ашиглахад зохих хувь нэмэр оруулсан. Түүнчлэн AVSF, "WCS" Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Австралийн Артур алигийн мэргэжилтнүүд болон хүрээлэнгийн эрдэмтэн судлаачидтай хамтран 7 сумдын төлөөллийг оролцуулан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Уг зөвлөлдөх уулзалтаар Хээрийн бүсийн экосистемийн төлөв байдлыг үнэлэх үнэлгээний талаарх санал авах, Малчдын мал маллагааны арга барилыг үнэлэх үнэлгээний шинэ систем нэвтрүүлэх саналыг малчдаас авах ажлыг зохион байгуулав. Эдгээр үнэлгээний систем нь олон талын оролцоог хангасан, энгийн ойлгомжтой боловч нарийвчилсан тоон үр дүнг гаргагдаараа давуу талтай. Уг зөвлөлдөх уулзалтад 50 төлөөлөл оролцсон. Судалгааны ажилд оролцсон багийн гишүүд 30\*30 метр буюу 900 м<sup>2</sup> талбайд шугаман цэгийн аргаар 480 цэгт хатгалт хийж мэдээллийг цуглуулан тус аймгийн хуурай хээр, хуурайдуу хээр цөлийн хээрийн бүсийн нутагт 15 орчим цэгээс ургамлын төрөл зүйлийг тодорхойлох судалгааг хийж газар дээр нь ургалтын бодит үнэлгээг хийлээ.

Сумдын хоршоодын удирдлагуудад үе шаттай сургалт зохион байгуулж хоршоодын БАХ-(Бэлчээр ашиглагчдын хэсэг)-уудаа өргөжүүлэхэд нь санхүүгийн болон мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаа. Тухайлбал өмнөх төслийн 5 сумын хоршоонд нийт 19 БАХ хамрагдаж байсан бол 2022 оны байдлаар 28 БАХ болж өргөжин тэлсэн. Мөн шинээр төсөл хэрэгжиж буй Баянцагаан, Баян-Өндөр сумдад нийт 26 БАХ байгуулагдсан ба төслийн хүрээнд байгуулагдсан, мөн хамтран ажиллаж байгаа 2 малчдын хоршоонд 8 БАХ хамрагдаж байна. 2023 оноос хоршоонд хамрагдах БАХ-ийн тоог 35-д хүргэхээр төлөвлөж ажиллаж байна. Энэ хүрээнд сум бүрд Бэлчээрийн менежментийн ажлын хэсэг буюу "Төслийн Зөвлөлдөх Хороо"-г байгуулан тодорхой хэмжээний санхүүгийн болон мэргэшил арга зүйн дэмжлэг өгч ажиллаж байна. Энэ хөтөлбөрийг Баянхонгор аймаг дахь

төслийн баг, сумдын МАА-н тасгийн бэлчээрийн мэргэжилтэн болон сумдын газрын даамалтай хамтран хэрэгжүүлж байна.

Жил бүр хамтран ажилладаг хоршоо бүрт “Тогтвортой ноолуурын Гэрчилгээжүүлэлтийн гадаад хяналт”-ыг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд Тогтвортой ноолуур гэрчилгээжүүлэлтийн гадаад хяналтыг зохион байгуулж, нийт 7 малчдын хоршооны 508 өрх гадаад хяналтад хамрагдаж 487 малчин өрх гадаад, дотоодын зах зээлд ноолуураа нэмүү өртөг шингээн борлуулах эрх бүхий “Тогтвортой ноолуурын Гэрчилгээ” авах болзлыг хангалаа. Тогтвортой ноолуур Гэрчилгээ авснаар малчид болон хоршоод Дундын хоршоогоороо дамжуулан гадаад, дотоодын зах зээлд ирэх 2023 онд ноолуураа нэмүү өртөг шингээн борлуулах боломжтой болж байгаа юм.

Агрономийн инженерийн дадлагыг удирдан чиглүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагааны хүрээнд сумдын малчдын хоршоо бүрт “Малчдын Мэдээллийн Сүлжээ”-г бий болгосон ба зорилго нь өнөөгийн малчин өрхийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал нь эрхэлж буй бэлчээрийн мал аж ахуйн онцлог, тоо толгой, төрөл зүйл, мөн оршин байгаа газар нутгийн онцлог, ойр болон алслагдмал орчин зэргээс хэрхэн шалтгаалдаг болохыг нарийвчлан судалж тогтоосноор хоршоодод өөрсдийнхөө техник-эдийн засгийн хяналт хийх аргачлалыг хөгжүүлэхэд оршиж байгаа юм. Уг “Малчдын мэдээллийн сүлжээ”-ний арга зүйг 2020 онд боловсруулж, 2021 оноос эхлэн 2 дахь жилдээ үргэлжилж байгаа ба 7 сумын хоршооны 84 малчин өрх “Малчдын мэдээллийн сүлжээ”-нд хамрагдаад байна. 3 жил үргэлжлэх энэ судалгаа, арга зүйн ажлын эхний судалгаа 2021 оны 8-9 саруудад хийгдсэн ба 2 дахь судалгаа 2022 оны 8 сард хийгдсэн. Судалгаанд Хөдөө Аж Ахуйн их сургуулийн дадлагажигч оюутнууд цуглуулсан мэдээлэлд дүгнэлт анализ хийж ажиллах ба эргээд бүх хоршоодын түвшинд бэхжүүлэх, сайжруулах ажлыг Баянхонгор дахь төслийн нэгж хариуцан ажиллаж байна.

Холбоо харилцааны платформ сүлжээг бий болгох/Тогтвортой ноолуурын нэмүү өртгийн сүлжээний олон төрлийн оролцогч талуудыг төрөл бүрийн түвшинд бүхэлд нь нэгтгэх хүрээнд 2021 онд аймгийн түвшинд “Тогтвортой ноолуурын Зөвлөлдөх Хороо”-г байгуулж, аймгийн Засаг даргатай “Хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурж баталгаажуулсан ба Богд, Жинст, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Бөмбөгөр сумдын Засаг даргын захирамжаар сумдын Төслийн Зөвлөлдөх хороог байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн.



Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн цогц систем бий болгох төслийн хүрээнд хоршоод нэгдэн “Ээлтэй баялаг” дундын хоршоог үүсгэн байгуулав. Дундын хоршоо нь гишүүн малчдын хоршоодын мал аж ахуйн бүтээгдэхүүн тэр дундаа ноолуурыг нэмүү өртөг шингээн зуучлан борлуулах үйл ажиллагааг явуулж малчдын хоршоодыг мэргэшил арга зүйгээр ханган ажиллаа.

Нийт 7 малчдын хоршоо нь Тогтвортой ноолуур холбоогоор дамжуулан гадаадын 5, дотоодын 4 худалдан авагчидтай гэрээ байгуулан 15,5 тн түүхий ноолуур бэлтгэн, экспортод 7,2 тн самнасан ноолуур, дотоодод 1,2 тн самнасан ноолуур борлуулсан. Үүний үр дүнд хоршоод 2,9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж, 8,8 сая төгрөгийн ашигтай ажилласан ба үүнээс хоршооны гишүүн өрхүүдэд ногдол ашиг олгож тэдний өрхийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна хоршооны 2023 оны үйл ажиллагааныхаа зардлыг бүрэн санхүүжүүлж, бэлчээр мал аж ахуйдаа хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон нь энэхүү ажлын хамгийн том амжилт байлаа.

Шинээр төсөл хэрэгжиж буй Баянцагаан, Баян-Өндөр сумдад бэлчээрийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

- o Сумдад Бэлчээрийн менежментийн ажлын хэсэг байгуулав.(БМ-АХ)
- o Сумдад Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийг байгуулав. (БАХ)
- o Баянцагаан сум- 14 БАХ
- o Баян-Өндөр сум-12 БАХ

2022 оны 12 сарын байдлаар зорилтот 2 шинэ суманд нийт 26 БАХ байгуулагдсан. Сумын нийт малчин өрх 100% БАХ-д хамрагдсан байна. Үүнээс 8 БАХ бүх гишүүдийн хурлаа зохион байгуулж 2 жилийн хугацаатай бэлчээрийн менежментийн төлөвлөгөөгөө баталсан нь үр дүнтэй байна. Энэ үйл ажиллагааны үр дүнд эдгээр 8 БАХ-дад суурилсан 2 шинэ малчдын хоршоо байгуулагдлаа. Үр дүнд нь 2021 оноос эдгээр хоршоод анх удаагаа гадаад дотоодын зах зээлд ноолуураа нэмүү өртөг шингээн борлуулах анхны гараагаа хийсэн байна. Өнөөдрийн байдлаар төсөл хэрэгжигч Богд, Жинст, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Бөмбөгөр сумдад 101 БАХ үүсгэн байгуулагдаж, бэлчээрийн хамтын менежментийг хэрэгжүүлж байна.

Баянхонгор аймгийн ХХААГ-тай гурвалсан гэрээ байгуулан ноолуурын микрон тодорхойлох багаж болон бусад тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн ба тус тоног төхөөрөмжийг ашиглалтын талаарх сургалтад ХХААГ-ын 2 мэргэжилтэнг хамруулан сургаж чадавхжуулсан.

2022 оны эцсээр AVSF ОУБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газраас Санхүүгийн менежерээр ахлуулсан баг Баянхонгор аймгийн Төслийн багт 2022 оны санхүүгийн дотоод хяналт, аудит зохион байгуулав. Аудитын үнэлгээгээр сайн үнэлэгдсэн ба 2022 онд төлөвлөсөн төслийн хэрэгжилт сайн байна.

Тогтвортой ноолуур төсөл нь 7 сумдад төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр 2022 онд:

-Бөмбөгөр, Шинэжинст, Богд, Жинст, Баянцагаан, Баян-Өндөр сумдын Өгөөж баян-Өлзийт гол, Цармын цагаан сувд, Орог нуурын хишиг, Түйн хишиг, Баянгичгэнэ, Идрэнгийн цагаан сувд зэрэг хоршоод нь 15,5 тонн ноолуур бэлтгэн гадаад зах зээлд 7,2 тн самнасан ноолуур, дотоод зах зээлд 1,2 тн самнасан ноолуур гэрээгээр борлуулж 2,9 тэр бум төгрөгийн борлуулалт хийсэн.

-Дээрх хоршоод 50-116 гишүүнтэй бөгөөд жил бүр гишүүдийнхээ тоог 10-15% хүртэл нэмж өргөжүүлсэн.

-Малчдын хоршоод хоршооны бүх гишүүдийн хурлаа жилд 2 удаа зохион байгуулж хэвшсэн ба эхний ээлжит хурлаа 2022 оны 2 сарын 21-нээс 26-ны хооронд, 2 дахь хурлаа 10 сарын 17-ноос 11 сарын 01-ний хооронд тус тус зохион байгуулсан. Хоршоод эхний ээлжит хурлаараа тухайн жилийн төсөв, төлөвлөгөөгөө хэлэлцэн баталдаг бол 2 дахь ээлжит хурлаараа жилийн ажлын тайлангаа тайлагнаж үр дүнгээ хэлэлцдэг.

Бөмбөгөр, Баацагаан, Шинэжинст сумдад “Тогтвортой ноолуур” төслийн хүрээнд хийсэн ажлын үр дүнгийн талаар кино зураг авалтын ажлыг зургийн багийн гишүүдтэй хамтран зохион байгуулав. 2022 оны 05 сар

AVSF, “WCS” Зэрлэг амьтадыг хамгаалах нийгэмлэг, Австралийн Артур алигийн мэргэжилтнүүд болон хүрээлэнгийн эрдэмтэн судлаачидтай хамтран төслийн 7 сумдын төлөөллийг оролцуулан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Түүнчлэн хуурайдуу хээр, хуурай хээр, цөлийн хээрийн бүсийн нутагт хээрийн судалгааны ажлыг зохион байгуулав. 2022 оны 08 сар

Говь-Алтай аймгийн Бугат сумын Тусгай хамгаалалттай газар болон Олон улсын Тахь группийн багийнхантай хамтран Биж, Ферм багуудын малчдад бэлчээр ашиглалтын хэсгийн зохион байгуулалт, хоршооны тухай ойлголт, хоршоо хэрхэн үүсгэн байгуулах, Баянхонгор аймгийн хоршоодын тэргүүн туршлагын талаар сургалт зохион байгуулав. 2022 оны 09 сар

Завхан аймгийн “Шимт Мандалын Өгөөж” хоршооны бүх гишүүдэд үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, хоршооны удирдлага болон бүлэг хариуцсан малчдад гэрчилгээжүүлэлтийн

дотоод хяналтыг хийх арга зүйн зөвлөмж өгөх, БАХ-ийн бэлчээрийн хамтын менежментийн төлөвлөгөө боловсруулах талаар сургалт зохион байгуулав. 2022 оны 11 сар

Төслийн гол санхүүжүүлэгч FFEM буюу Дэлхийн байгаль орчны төлөө Францын сангаас 2022 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн 228,475 еврогийн санхүүжилтээс бүтэн жилээр боловсруулсан үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөө ёсоор нийт 173,509 евро төлөвлөгдөж батлагдсан төсвийн хүрээнд зарцуулагдсан. Гүйцэтгэл 76%. Төслийн хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилт 100%.

### Утаагүй Баянхонгор төсөл

Энэ төсөл 3 зорилгын хүрээнд нийт 80 арга хэмжээ төлөвлөсөн. Зорилгууд нь:

- Эх, хүүхдийн агаарын бохирдолд өртөлтийг бууруулах
- Агаарын бохирдлыг бууруулах
- Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах зорилттой.
- Хэрэгжих хугацаа нь 2019–2022 онд
- Нийт төсөв 2,1 тэрбум төгрөг
- Хэрэгжилтийн хувь: 95%

Орон нутгийн төсөв:

2019 – 96 сая төгрөг

2020 – 288 сая төгрөг

2021 – 150 сая төгрөг

2022 – 150 сая төгрөг

НҮБ-ын Хүүхдийн Сан болон бусад эх үүсвэр: 2019-2021 онд 1,3 тэрбум төгрөг

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын гэр хорооллын өрхүүдэд ЧИП багцыг нэвтрүүлж, нийт 600 өрхөд суурилуулсан. Хоёр дэд станцыг эрчим хүчний чадал дутагдаж байгаа газруудад шинээр барьсан.

Баянхонгор аймаг	Он	Нийт өрх	Эмэгтэй	Эрэгтэй	0-5 насны хүүхэд	Өрх толгойлсон эх	Өрх толгойлсон эцэг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Ахмад настан
ЧИП багц авсан өрхийн тоо	2019	230	139	147	77	12	3	16	86
	2020	109	355	205	79	5	1	9	48
	2021	165	154	144	78	5	1	12	65
	2022	96	86	70	50	5	1	10	70
Нийт		600	734	566	284	27	6	47	269

Инновацийн төвд сургалт явуулах танхимын байнгын үйл ажиллагааг хангахын тулд засвар үйлчилгээ хийж, олон нийтэд мэдээлэл, мэдлэг түгээх ажлыг цаасан болон цахим, танхимаар сургалтаар хүргэж ажилласан байна.

2021 онд ЧИП багц нэвтрүүлсэн өрхүүд нь:

- Татаас: орон нутгийн төсвөөс 100%: 30 айл
- Татаас: 77 айл өрх 60% хувийн татаас, нийт 101,640,000 төгрөг
- Банкны ногоон зээл: 8% хүүтэй, 11 өрхийн нийт 7,920,000 төгрөг
- ББСБ-ын зээл: 34.8% хүүтэй, 12 өрхийн нийт 8,640,000 төгрөгөөр хамрагдсан байна.

Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 302 тушаалаар 85 сая (НҮБ-ын Хүүхдийн Сан) төгрөгийн санхүүжилтээр эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлсэн ба Ковид цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд нярай амьсгалын аппарат, хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч, бусад дагалдах хэрэгсэл, эм, вакцин, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, вакцинаторын сургалтууд, хувийн хувцас хамгаалах хэрэгслийг 500 сая төгрөг (НҮБ-ын Хүүхдийн Сангийн бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд) санхүүжилтээр ОНЭМА сургалтанд оролцогсад олгосон.

Үр дүн нь эх, хүүхдийн тусламж үйлчилгээний хожимдол, тасалдал байгаагүй, үндсэн үзүүлэлт урьд оны түвшинд байна. Мөн:

- Шинээр 300 хүүхдийг Агаарын бохирдлын сайн дурын идэвхтэн болгосон.
- 5 хүүхэд өсвөрийн парламентийн гишүүнээр сонгогдон ажиллаж уур амьсгалын өөрчлөлт, хог хаягдал, орчны бохирдлын чиглэлээр сургалт хийж таван газарт батарей хаях хогийн сав хийж байршуулсан.
- Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлыг бууруулах талаар сургалт, нөлөөллийн ажлууд хийж нийт 520 сурагч танхимаар, 1086 хүүхэд цахимаар сургалт нийт 1606 хамрагдсан.
- Цэвэр агаар бидний ирээдүй нээлттэй санал асуулга аймгийн хэмжээнд цахимаар явуулж байна. Одоогоор 500 гаруй хүн оролцсон. Гарсан үр дүнг иргэд болон шийдвэр гаргагч нарт танилцуулж, нөлөөллийн ажил хийнэ.

Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг эхлүүлэхэд 4 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж байна.

Төслийн хугацаанд гэр хорооллын айл өрхийн 10% нь ЧИП багцад хамрагдсан байна.

**“Малчдын эрүүл мэндийг хамгаалах, малчдыг аливаа эрсдэлт өвчин эмгэгээс сэргийлэх” төсөл**

Баянхонгор аймгийн бүх сумдаар малчдад эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулсан байх зорилготой.

Нийт санхүүжилт 62 сая төгрөг. Австралийн элчин сайдын яамны шууд санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан, 1 жилийн хугацаатай.

Малчдын эрүүл мэндийг дэмжих төслийг аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, 20 сумдын Эрүүл мэндийн төвүүд хамтран хэрэгжүүлсэн. Малчдын эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөөнд 12 ажил арга хэмжээг тусган, хэрэгжүүлснээр хэрэгжилт 90 хувьтай байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумдын 20 эрүүл мэндийн төвийн дарга удирдлага, эмч мэргэжилтнүүдтэй 2022 оны 10 дугаар сарын 24-ны өдөр цахимаар уулзалт хийж, танилцуулга сургалт зохион байгуулсан. Уг сургалтаар төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалтын онцлог, талуудын оролцоо хариуцсан ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн. Мөн урьдчилан сэргийлэх үзлэгийн бүртгэлийн хуудас, тайлан нэгтгэх талаар зааварчилгаа өгч, байгууллагуудын саналыг хэлэлцсэн.

Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, малчдыг эрүүл мэндийн оношилгоонд хамруулах ажлын хүрээнд нийт малчдын 40 түүнээс дээш хувийг хамруулахаар төлөвлөж урьдчилан сэргийлэх үзлэгийг 2022 оны 10 дугаар сарын 17-наас 11 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулсан. Малчдын эрүүл мэндийг дэмжих төслийн хүрээнд нийт малчдын 41.7 хувийг үзлэг оношилгоонд хамруулсан.

Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдсан 5682 малчнаас 1147 хүн эрүүл мэндийн эрсдэлтэй гэж оношлогдсон ба дараагийн шатлалын лавлагаа, төрөлжсөн эмнэлэгт нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай малчин 633, стационарт онош тодруулах, хэвтэн эмчлүүлэх шаардлагатай малчин 511, сувилалд эмчлүүлэх шаардлагатай малчин 540 байна.

Дээрх эрүүл мэндийн эрсдэлт бүлэгт харьяалагдаж байгаа 1147 малчин, онош тодруулах шаардлагатай 633 малчныг илрүүлсэн нь үзлэг оношилгооны үр дүн юм.

Үзлэгт хамрагдсан малчдыг хүйсээр авч үзвэл эмэгтэй 2854, эрэгтэй 2828 хүн байна.

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд цаашид хэвтүүлэн эмчлэх шаардлагатай дээрх 511 малчдыг системтэйгээр хэвтүүлэн эмчилж, эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн үзлэгт хамрагдсан малчдын 58 хувь нь илүүдэл жинтэй, 43 хувь нь зохисгүй хооллолттой, 36 хувь нь хорт зуршлын хэрэглээтэй байгааг асуумжаар гаргаж, нийгмийн эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөнд хамрууллаа.

Үзлэг оношилгоог сумдын эрүүл мэндийн төв болон хөдөөгийн багийн төвүүд дээр очиж зохион байгуулж, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, хүүхэд, дотрын өвчин судлал, хэт авианы оношилгооны чиглэлээр мэргэшсэн эмч нар үзлэг оношилгоог зохион байгуулсан. Хөдөөгийн эмнэлгүүдийн нарийн мэргэжил эзэмшсэн, мэргэжил дээшлүүлсэн 20 эмчлэгч эмчийг сонгон үзлэг оношилгоог хамтран зохион байгуулсан. Сумдын эмч нарын анкет танилцуулгыг архивлан бүрдүүлсэн байна.

Сургалт сурталчилгаанд ашиглах хорт хавдраас сэргийлэх, хуванцар савны хэрэглээнээс татгалзах, анхны тусламж үзүүлэх, зохистой хооллолтын зөвлөгөө, халдварт бус өвчин эмгэгээс сэргийлэх зэрэг 5 төрлийн 100 ширхэг суурилуулагч хөлтэй баннерыг 20 суманд хүргүүлэн нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд ашигласан.

Эрүүл амьдралын дадал хэвшлийн талаар хуванцар савны хэрэглээнээс татгалзах, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 сэдвээр 5000 ширхэг гарын авлага, брошюрыг бэлтгэн сумдад хүргүүлэн, малчдын сургалтад ашигласан. Сумдын Засаг даргын тамгын газруудад албан бичиг хүргүүлж, 20 сумын малчдын судалгаа авсан. Судалгааг цаасаар болон файл хэлбэрээр CD болгож хадгалсан.

Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд албан бичгээр судалгааны загварыг сумдад хүргүүлж, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээр дамжуулан сумдын байцаагч нартай хамтран судалгааг жагсаалтаар гаргаж, судалгаанд үндэслэн 20 сумын 85 малчны эрүүл мэндийн даатгалыг 1 удаа төлж, 4.2 сая төгрөгийг холбогдох баримтад үндэслэн Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлсэн.

Үзлэг оношилгоонд ашиглагдах үзлэгийн бээлий, малгай, хамгаалах хувцас, амны хаалт, вакум тейнер, ЭХО-ны гель зэрэг 8 нэр төрлийн 15650 ширхэг эмнэлгийн нэг удаагийн үзлэгийн хэрэгслээр Сумдын эрүүл мэндийн төвүүдийг хангасан. Төслийн хэрэгжилт 90%.

**“Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл:**

НҮБ-ын Хүүхдийн Сан, БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага KOICA-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл нь “Зорилтот орон нутгийн эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны байгууллагуудын түвшинд Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг хуульчлах, баталгаажуулах, төсөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалт хийх чадавхыг сайжруулах”, сургууль, цэцэрлэг, дотуур байрны түвшинд “Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн талаар баримтлах үндэсний стандарт, шаардлагыг нэмэгдүүлэх” зорилготой.

Орон нутгийн УАЦЭА-тай холбогдох бодлого, төлөвлөлтийг уур амьсгалын болзошгүй өөрчлөлттэй уялдуулан сайжруулах зорилтын хүрээнд:

1. Сумдын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг сайжруулж хэрэгжүүлэхэд 21,188,750 төгрөгийг зарцуулсан, хэрэгжилт- 90%.

2. Сумдын Өвөлжилтийн бэлэн байдлын төлөвлөгөө, гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг сайжруулж хүүхдэд ээлтэй болгоход 10,378,700 төгрөгийг зарцуулсан хэрэгжилт- 85%. Нийт санхүүжилт 31,567,450.

Уур амьсгалын болзошгүй өөрчлөлтийг харгалзсан УАЦЭА-н байгууламжийн шинэлэг шийдэл болон эрчим хүчний хангамжийн тогтвортой хувилбаруудыг хүүхдэд ээлтэй байдлаар бий болгох зорилтын хүрээнд:

Хүрээмарал сумын сургуулийн ариун цэврийн өрөөний өргөтгөл-151,816,493, Заг сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл-88,870,115, Баян-Өндөр сумын цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар-124,925,222, Бууцагаан сумын нийтийн ариун цэврийн байгууламж-130,500,000, Гурванбулаг сумын дотуур байрны ариун цэврийн өрөөний өргөтгөл-168,699,520, Эрдэнэцогт сумын ундны усны гүний худгийн барилга-65,434,983, Эрдэнэцогт сумын ундны усны гүний худгийн ухаалаг төхөөрөмж-15,208,949, Эрдэнэцогт сумын нийтийн халуун усны хашаа тохижилт-30,420,553, Баянхонгор сумын Чандмань-Баянхонгор ХК-ний зөөврийн ус түгээх байр-017 засвар тохижилт, ухаалаг төхөөрөмж-19,816,125, Баянхонгор сумын Чандмань-Баянхонгор ХК-ний зөөврийн ус түгээх байр-013 засвар тохижилт, ухаалаг төхөөрөмж-19,816,125, Галуут сумын цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар-139,812,503, Богд сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний өргөтгөл-97,711,836, Богд сумын төвийн худгийн ус цэвэршүүлэх

төхөөрөмж-11,490,000, Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн ариун цэврийн өрөөний засвар-39,004,511, Баянхонгор сумын Түүх угсаатны зүй, байгалийн түүхийн музейн нийтийн ариун цэврийн байгууламж-111,225,090, Баянхонгор сумын Эрдэм, Эрдэнэмандал ахлах сургуулийн ариун цэврийн өрөөнд охидын өрөө тохижуулах-1,945,000, нийт 1,216,697,025 төгрөгийн санхүүжилт бүхий ажлуудыг 100% гүйцэтгэсэн байна.

Нийт сургуулийн 71,4%, дотуур байрны 72,7%, хүүхдийн цэцэрлэгийн 88,5% нь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болсон.

Төслийн үр дүнгийн явцын талаар хяналт, мониторинг хийж, сайн туршлага, сургамжийг баримтжуулах, дэлгэрүүлэх ажлын хүрээнд

Нийт 15 ус хангамж, ариун цэврийн байгууламжийн ажилд хяналт тавьж ашиглалтад оруулах-9,886,500, Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн сайн туршлагын эмхэтгэл хийх-2,650,000 /500ш сэтгүүл гаргасан/ нийт 12,536,500 төгрөгийн санхүүжилтээр 100% гүйцэтгэсэн. Төслийн хэрэгжилт 98%.

**“Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” төсөл:**

Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөгч бэлтгэх сургалтыг НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилт 26.630.520 төгрөгийн санхүүжилтээр 2 ээлжээр зохион байгуулснаар Нэгдсэн эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төвийн 59 эмч, мэргэжилтнийг хамрууллаа.

Оролцогчдын сургалтын өмнөх мэдлэг 69.5% байсан бол сургалтын дараа 96.5% болж 27 хувиар нэмэгдсэн.

Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын тандагч бэлтгэх сургалтыг НҮБ-ийн Хүүхдийн сангийн 4,749.940 төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж сум, өрхийн эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн газрын 20 эрүүл мэндийн ажилтныг хамруулсан. Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөгч нарын зөвлөгөө өгөлтийг хянах, үнэлэх арга зүйд суралцсан. Үр дүнд олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын тандагчгүй сумдад тандагч бэлтгэн НБНХХ-ын тандалтын үнэлгээг тогтмолжуулж, тасралтгүй хийх боломж бүрдсэн.

НҮБ-ийн Хүүхдийн сангийн 17.300.000 төгрөгийн санхүүжилтээр 06-23 сар хүртэлх насны хооллолтын бэрхшээл, жингийн алдагдалтай, өвчлөмтгий хүүхдүүдийг эрүүлжүүлэх, жингийн алдагдлаас гаргах, зорилгоор Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Баянлиг, Бууцагаан, Баянбулаг, Баянговь, Баян-Овоо, Богд, Бөмбөгөр, Гурванбулаг, Шинэжинст, Хүрээмарал, Өлзийт, Жаргалант,



Наранмандал, Энхбүрд гэсэн нийт 15 сум, 2 өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд 173 хүүхдийг хамруулан 10 хоногийн хугацаатай түр сувиллын үйл ажиллагаа зохион байгуулсан.

Түр сувиллын үйл ажиллагаа зохион байгуулснаар хүүхдүүдийн жин дунджаар 300 гр нэмэгдэн, эцэг эх асран хамгаалагч нар хүүхдийн асаргаа, бие бялдрын хөгжил чийрэгжилт, хооллолтын талаар мэдлэгтэй болсон.

Нийт 48.580.460 төгрөгийн санхүүжилт зарцуулсан, төслийн хэрэгжилт 100%.

**“Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах” төсөл хөтөлбөр:**

НҮБ-ын Хүүхдийн сан 5,585,000 төгрөгийн санхүүжилтээр Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж Эрүүл мэндийн салбарын нийт 23 эмч мэргэжилтэнг сургагч багшаар бэлтгэсэн. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 75, Олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг сургаж чадавхжуулаад байна.

ДЭМБ 6,553,000 төгрөгийн санхүүжилтээр Ковид 19 халдварын үеийн хүүхдийн эрэмбэлэн ангилалт сэдвээр сургалт зохион байгуулж, 24 эмч мэргэжилтэнг сургалтад хамруулсан. мэдлэгийн түвшин 40 хувь нэмэгдэж 90 хувьд хүрсэн.

ДЭМБ 10,249,000 төгрөгийн санхүүжилтээр Ковид 19 халдварын үеийн нэн шаардлагатай яаралтай тусламж үйлчилгээний сургалтуудад бүх шатны эрүүл мэндийн байгууллагын 72 эмч эмнэлгийн мэргэжилтэнг хамруулж, мэдлэгийн түвшин 45 хувиар нэмэгдэж 80 хувь болсон.

ДЭМБ-ын 46.591,988 төгрөгийн санхүүжилтээр Баянхонгор аймгийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн давтан сургах, чадавхжуулах, салбар дундын хамтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 7 үйл ажиллагаа төлөвлөж, амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Цар тахлын үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн мэргэжлийн багийн гишүүдийг бүрэн чадавхжуулан сургасан. Ажлын байрны сургалтаар дадлага сургалтыг 100 хувь хэрэгжүүлсэн.

ДЭМБ-ын 46.297,335 төгрөгийн санхүүжилтээр “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ,

сургалт, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулж, Эрүүл мэндийн газрын дарга, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, 6 мэргэжилтэн, өрхийн эрүүл мэндийн төвийн 17 эмч, эмнэлгийн ажилчид, сумын эрүүл мэндийн төвийн 59 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамрагдаж мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэн ажилласан. Сургалтын дараа мобайл технологийн багцын үзлэг нийт үзлэгийн (27645) 25 хувийг эзэлж байна.

Нийт 115.376.323 төгрөгийн санхүүжилт зарцуулсан, төслийн хэрэгжилт 96,8%.

**“Best” хөтөлбөр:**

2008 оны 8 сарын 14 өдөр үүсгэн байгуулагдсанаасаа хойш хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийнхөө хүрээнд харилцагч бүрийнхээ өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжих олон талын үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байна. АНУ-ын ОУ-ын Хөгжлийн агентлаг (USAID) Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил тод байдлыг нэмэгдүүлэх (BEST) төслийг Монгол Улсад шинээр эхлэх болсноо 2019 оны 12 дугаар сарын 11-нд зарласан. Хөтөлбөрийн зорилго: Жижиг дунд бизнесүүд, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар МУ-ын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөхөд чиглэнэ. Зорилго нь:

1. Жижиг дунд бизнесийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх- зорилтын хүрээнд сургалт уулзалт, зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх
2. Жижиг дунд бизнесийн компанийн засаглалыг сайжруулах
3. Жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах
4. Жижиг дунд бизнесийн хөгжлийн стратегийг тодорхойлоход чиглэсэн судалгаа хийж гүйцэтгэх
5. Цаашид тогтвортой хөгжих боломжтой боловч санхүүжилт авах чадамжгүй гарааны болон жижиг бизнесүүд, ТББ-уудад бичил санхүүжилт олгох хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах:

Хөтөлбөрийн хүрээнд:

1. Бизнесийн зөвлөх үйлчилгээ
2. Бизнесийн сургалтууд
3. Мэдээллийн үйлчилгээ
4. Борлуулалтыг дэмжих үйлчилгээ
5. Төсөл хөтөлбөр гэсэн чиглэлээр үйлчилгээг үзүүлж байна.

2021 оны 10 сарын 01-ээс 2022 оны 09 сарын 30-ны байдлаар 177 харилцагчид 53,260,000,000 төгрөгийн зээлийн зуучлал хийж гүйцэтгэл 100% гүйцэтгэлтэй байна. Батлагдсан зээл 126 харилцагч нарт 3,456,100,000 төгрөгийн зээлийг батлуулж төлөвлөгөөний гүйцэтгэл 96% -ийн гүйцэтгэлтэй байна.

Нийт 33 удаагийн сургалтад 673 иргэн, 16 удаагийн уулзалтад 376 иргэн, 1 удаагийн зөвлөх уулзалтад 19 иргэн оролцсон. Тайлант хугацааны гүйцэтгэл 100%.

**“Тогтвортой Амьжиргаа-3” төсөл:**

- 1.Сумдын удирдах албан тушаалтнуудын туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах
- 2.ОНХС-ийн журмын өөрчлөлтийн мэдээллүүд, ЖГҮ-ний анхаарах асуудлууд, УМС, цахим санал авах аппликейшны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийх,
- 3.“ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдэд Байгаль орчны үнэлгээ хийх нь” цахим сургалт зохион байгуулах зорилготой.

Дэлхийн банкны 19,934,500 төгрөгийн санхүүжилтээр Сумдын удирдах албан тушаалтнуудын туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах, ОНХС-ийн журмын өөрчлөлтийн мэдээллүүд, ЖГҮ-ний анхаарах асуудлууд, УМС, цахим санал авах аппликейшны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийх, “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдэд Байгаль орчны үнэлгээ хийх нь” цахим сургалтууд зохион байгуулагдсан. Нийт 6 төрлийн 44 удаагийн сургалтад 388 албан хаагчдыг хамруулж чадавхжуулсан байна.

Сумдын төрийн албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах арга хэмжээний хүрээнд сумын удирдлагууд буюу 20 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, Санхүүгийн албаны дарга, ОНХС хариуцсан нягтлан бодогчид нийт 80 хүн, ОНХС-ийн холбогдох албан хаагчдыг хамруулсан, аймгийн Санхүү хяналт дотоод аудит, Төрийн аудит, АЧББ-ийн гишүүдийн төлөөлөл оролцсон туршлага солилцох арга хэмжээг Жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр сүүлийн жилүүдэд улс, аймагтаа тэргүүлж байгаа Өлзийт, Гурванбулаг сумдад бүсчлэн зохион байгуулж харилцан туршлагаа хуваалцсанаараа онцлог болсон.

Аймгийн 20 сумд ОНХС-ийн гарын авлагын модулийн сургалт, ЖГҮ-ний 2021 оны үр дүнгийн танилцуулга, 2022 оны үнэлгээ хийлгэх арга зүйн зөвлөн туслах арга хэмжээг 7-8 сард газар дээр нь очиж зохион байгуулсан. ЖГҮ-ээр хяналт шинжилгээ, үнэлгээ бүлгийн үнэгээ хангалтгүй байсан зарим сумд Баянлиг, Шинэжинст, Баян-Өндөр, Галуут, Жаргалант сумдад очиж, ИТХ-ын дэргэдэх

хяналтын хороо, ЗДТГ-ын хяналтын ажлын хэсгийн гишүүдэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар сургалтыг хийж, зөвлөн туслах чиглэлээр ажилласан.

Үүний үр дүнд Тогтвортой амьжиргаа-3 төслийн хүрээнд сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд 2016 оноос хойш хийгдэж буй Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний 2022 онд хийгдсэн үр дүнгээр Баянхонгор аймгийн 20 сумаас 16 сум амжилттай үнэлэгдэж 2023 оны ОНХС-ийн төсөвтөө 957.2 сая төгрөгийн нэмэлт урамшууллыг авсан.


Манай аймгийн 20 сум Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 2017-2023 онуудад ОНХС-ийн нэмэлт урамшуулал 3,163.5 сая, дэмжлэг 1,704.0 сая, дэд төсөл, сургалт арга хэмжээнд 232.8 сая нийт **5,100.2** сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС-ийн төсөв дээрээ нэмэлтээр авч иргэдийнхээ саналд тулгуурлан орон нутгийнхаа иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хөгжил, бүтээн байгуулалтын ажилд зарцуулж байна.

Баянхонгор аймгийн сумдад олгосон урамшуулал, дэмжлэг,  
чадавхжуулах арга хэмжээ 2022 оны байдлаар



д/д	Үзүүлэлтүүд	Онууд							Нийт санхүүжилт
		2016	2017	2018	2019	2020	2021	2022	
1	Урамшуулал	262,225.1	22,455.2	311,846.8	462,568.8	442,922.1	704,249.4	957,214.1	3,163,481.5
2	ОНХС-ийн дэмжлэг	0.0	825,448.6	553,382.3	188,000.0	137,129.5	0.0	0.0	1,703,960.4
3	Дэд төсөл, сургалт арга хэмжээ	0.0	17,083.5	34,634.3	134,367.5	2,487.0	21,970.5	22,234.5	232,777.3
	<b>Нийт дүн</b>	<b>262,225.1</b>	<b>864,987.3</b>	<b>899,863.4</b>	<b>784,936.3</b>	<b>582,538.6</b>	<b>726,219.9</b>	<b>979,448.6</b>	<b>5,100,219.2</b>

## Баянхонгор аймгийн 20 сум 2017-2023 онд авсан ЖГҮ-ний үр дүнгийн урамшуулал, дэмжлэг



Сургалтын цахим платформд сумдын Багийн Засаг дарга нарыг хамруулах ажлыг сумдын ОНХС хариуцсан нягтлан бодогчидтой хамтран зохион байгуулж ажилласан. Энэ арга хэмжээнд 20 сумын 97 БЗД хамрагдаж суралцан сертификат гардаж авсан.

БОНУ-ний цахим сургалтад аймаг, сумдын холбогдох албан тушаалтнууд аймгийн БОАЖГ-ын дарга, БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны байцаагч, ОНХС-ийн ажилтан, сумдын засаг дарга, байгаль орчны байцаагч, газрын даамал, багийн засаг дарга нарыг хамруулан зохион байгуулсан.

Аймгийн ЗДТГ, ИТХ, сумдын ЗДТГ-ын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албан тушаалтнуудад ОНХС-ийн үйл ажиллагаа, үрд дүн, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийг мэдлэг мэдээллээр хангах чиглэлд хамтран ажиллах талаар цахим сургалтыг төсөл хэрэгжүүлэх нэгжээс зохион байгуулснаар аймаг, сумдын 22 албан хаагч оролцсон.

УМС-ийн ашиглалтыг сайжруулах зорилгоор аймгийн хяналтын байгууллагуудыг мэдээллээр хангаж, системээс мэдээллээ авах, УМС-д хяналт тавьж ажиллах талаар мэдээлэл тогтмол өгч, сумдын удирдлагууд, төрийн албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчдөд танилцуулга мэдээлэл өгч ашиглалтыг сайжруулах, ОНХС-ийн урд оны гүйцэтгэл, тайлан дараа оны батлагдсан төсвийг иргэдэд мэдээлэх, тайлагнахыг Санхүүгийн албаны дарга, сан хариуцсан нягтлан бодогч нарт зөвлөж ажилласнаар энэ ажил тогтмолжсон. Тайлант хугацааны төслийн хэрэгжилт 100%.

**Гурав. Дүгнэлт:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг сум, агентлаг, бодлогын хэлтсүүд хэрэгжүүлж ажиллаагүй, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцож, тайлан мэдээг нэгтгэхгүй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.6.6, аймгийн Засаг даргын 2022 оны А/236 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 3.2.3.13 дахь заалтыг хэрэгжүүлэн сум, агентлаг, бодлогын хэлтсүүд тайланг хугацаанд нь цаглаврын дагуу ирүүлж байх;

ТАНИЛЦСАН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.МАНДАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХТУЯА